



СҮХБААТАР АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРООНД

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024. 08. 08 № 438  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр  
хуульд заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Ардын намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр ( ..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

Сүхбаатар аймгийн МАН-ын хорооны  
Тэргүүлэгчдийн 2024 оны 06 дугаар сарын  
25-ны өдрийн хурлаар батлав.

**СҮХБААТАР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**  
**2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ**  
**“НЭГ БОДЛОГО-НЭГ ЗОРИЛТ-НЭГ БАГ”**  
**МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН**  
**БОДЛОГО**

**ЗОРИЛТ:** *Иргэдээ дээдэлсэн хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эрх чөлөөтэй, эрүүл, боловсролтой, ажилтай орлоготой иргэнийг хөгжүүлж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.*

**1.1. Орон сууц**

1.1.1 “Бага өртөгтэй орон сууц”, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж инженерийн хангамжтай орон сууцаар иргэдээ хангана.

1.1.2 Гэр хорооллын газрыг дахин барилгажуулах төсөл, зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл, Шинэ сууришлийн бүс хөгжүүлэх төсөл, Түрээсийн орон сууц төсөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлж ажиллана.

1.1.3 Аймаг, сумын төвийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар дэмжих замаар газрыг шийдвэрлэж, залуу гэр бүл, дундаж болон түүнээс доогуур орлоготой иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.4 Гэр хороолол дахь хашаа байшинтай айл өрхүүдийг инженерийн дэд бүтцэд холбож орчин үеийн эко хороолол барих төслийг хэрэгжүүлнэ.

1.1.5 Эрдэнэцагаан сумын Бичигт боомтод төрийн албан хаагчид, Хил хамгаалах байгууллагын ажилтан алба хаагчдын амьдрах орон сууц барих төслийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

1.1.6 Сумдад төрийн албан хаагчид, эмч, багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдын орон сууцыг барих төслийн ажлыг үе шаттай эхлүүлнэ.


1.1.7 Аймаг, сум орон нутагт баригдаж буй орон сууцны төлөвлөлтөд ногоон байгууламж, авто машины зогсоол, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллана.

## 1.2. Эрүүл мэнд

- 1.2.1 Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсрол, чадавхыг дээшлүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн бүрэн үзлэг оношилгоонд жил бүр заавал хамруулна.
- 1.2.2 Эмч, тусгай мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гадаад дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулна
- 1.2.3 Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээнд цахим эрүүл мэндийн системийг бүрэн нэвтрүүлж, эмчлүүлэгчдийн хувийн нууцыг хамгаалж, зардал, хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.
- 1.2.4 Хавдар, зүрх судасны өвчлөлийг эрт илрүүлэх оношилгоо, эмчилгээний шинэ арга зүй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн орон нутагтаа эмчлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.5 Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгслээр сумдын эрүүл мэндийн төвүүдийг хангаж үйлчилгээг сайжруулна.
- 1.2.6 Багуудын өрхийн эрүүл мэндийн төвийн материаллаг баазыг бэхжүүлж, үйл ажиллагааг сайжруулан эмнэлгийн анхан шатны үйлчилгээг иргэдэд ойртуулна. Аймгийн төвийн баг болгоныг ЭМТ-тэй болгох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 1.2.7 “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.2.8 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.9 Сумдын эмнэлгийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.
- 1.2.10 Аймгийн нэгдсэн эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, түүний дэргэд 40-60 ортой хүүхдийн эмнэлэг шинээр барина.
- 1.2.11 Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах, хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.
- 1.2.12 Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д суралцаж байх үеэс олгож, эрүүл мэндийн “анхны тусламж” үзүүлэх чадавхыг хүн бүрд

эзэмшүүлнэ. Эрүүл мэндийн боловсролыг “насан туршийн боловсрол”-ын системээр тогтмол олгоно.

- 1.2.13 Хөдөөгийн багт ажиллах эмчийг бодлогоор дэмжиж, тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.




### 1.3. Боловсрол, соёл

- 1.3.1 Орон нутагтаа ЕБС, Цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмж, урамшууллын хөтөлбөрийг бий болгох, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.
- 1.3.2 Баруун-Урт суманд 200 хүүхдийн 3-р цэцэрлэг, 3, 5, 6 дугаар багт шинээр хүүхдийн цэцэрлэг барьж ашиглалтад оруулна.
- 1.3.3 Эрдэнэцагаан, Сүхбаатар, Уулбаян сумдад 200 хүүхдийн, Баяндэлгэр, Дарьганга сумдад 150-200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барьж ашиглалтад оруулан, сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулна.
- 1.3.4 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг хамруулах боломжтой болгож, яслийн үйлчилгээг сэргээнэ.
- 1.3.5 Баруун-Урт суманд 960 хүүхдийн шинэ сургууль, 320 хүүхдийн сургуулийн өргөтгөл, Асгат суманд 160, Дарьганга суманд 320 хүүхдийн сургуулийн барилга барьж ашиглалтад оруулна.
- 1.3.6 Баруун-Урт, Эрдэнэцагаан, Мөнххаан сумдын 640, Түвшинширээ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгуудыг дуусгаж ашиглалтад оруулна.
- 1.3.7 ЕБС-ийг аймгийн хэмжээнд 1 ээлжтэй болгож хүүхэд багачуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх дугуйлан секцэд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.8 Сургуулиуд өдөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.
- 1.3.9 Үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, “Сүхбаатарын сайхан бичигтэн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.10 Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлын үр дүнг сайжруулах зорилгоор “Нутгийн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.11 Аялал жуулчлалын чиглэлээр мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт явуулах ангийг МБСургуульд нээхэд Боловсролын яамтай хамтран ажиллана..

- 1.3.12 “Шинжлэх ухаанч-Сүхбаатарын хүүхдүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлж олон улсад хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг орон нутагтаа нутагшуулах байгалийн ухааны хичээлийн чиглэлээр улс, бүсэд манлайлах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.13 Түмэнцогт, Онгон, Сүхбаатар сумдад соёлын төв барьж ашиглалтад оруулна.
- 1.3.14 “Дэлхийд өрсөлдөгч Сүхбаатарынхан” хөтөлбөр хэрэгжүүлж Монгол Улсыг төлөөлөн тив, дэлхий, бүсийн олимпиад, тэмцээн уралдаанд аймаг, орон нутгаа төлөөлөн өрсөлдөж буй баг, багш, хамт олныг дэмжиж урамшуулна.
- 1.3.15 Хүүхдийн сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлж “Залуу техникчдийн төв” байгуулан дэмжин ажиллана.
- 1.3.16 Дарьганга хүүхдийн зусланг барьж ашиглалтад оруулна.
- 1.3.17 “Хүүхдүүд-Бидний ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлж цэцэрлэгийн болон бага ангийн хүүхдүүдэд Монгол өв соёлоо эзэмшүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.3.18 “Төлөвшсөн хүүхдүүд-Бидний ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлж хүмүүжил, төлөвшлийн чиглэлээр “Дөл” тэмцээн, “Жагсаалч хамт олон” зэрэг уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж, хүүхдийн “Хөдөлмөр зуслан” нээн ажиллуулна.
- 1.3.19 Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, техник тоног төхөөрөмжөөр ханган, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлнэ.
- 1.3.20 Сумдын сургуулийн дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, малчдын хүүхдийг сурч боловсрох аятай тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор Баяндэлгэр, Онгон, Дарьганга сумдад дотуур байр барьж ашиглалтад оруулна.
- 1.3.21 Сургууль цэцэрлэгийн техник тоног төхөөрөмж, материаллаг баазыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж ажиллана.
- 1.3.22 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэн хамтран ажиллана.
- 1.3.23 Сумдын цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

- 1.3.24 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэгдсэн чанартай сургалтыг зохион байгуулахад шаардлагатай материаллаг баазаар сургууль, цэцэрлэгийг бүрэн хангана.
- 1.3.25 Хөдөөгийн багуудад зуны гэр цэцэрлэг ажиллуулж малчдын хүүхдийг сурч хүмүүжих орчинг бүрдүүлж шат дараатай хамруулна.
- 1.3.26 Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сурлагын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.27 Аймгийн МБС-ийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж материаллаг баазыг бэхжүүлэн суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.3.28 Мэргэжлийн боловсролын сургуулийн хичээлийн байрны шинэ барилгын ажлыг эхлүүлнэ
- 1.3.29 Зүүн бүсдээ жишиг “Багш хөгжлийн төв”-ийг шинээр байгуулж орон нутгийн БШУГ-ын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.
- 1.3.30 Монгол өв, соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох хүүхэд залуучуудад хүргэх хүрээнд иргэдэд өв уламжлагдан хадгалагдаж буй түүх соёлын эд өлгий, уран дархчуудын бүтээл болон ховор наднин бүтээл цуглуулагчдын “Сүхбаатарчуудын наднин өв соёл” олон улсын үзэсгэлэнг жил бүр зохион байгуулна.
- 1.3.31 Аймгийн хэмжээнд байгаа түүх, соёлын биет болон биет бус өв соёлын эд зүйлийг бүртгэлжүүлэн цахим системд оруулан хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хамгаалж байгаа иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 1.3.32 Уул уурхай, эрчим хүч, барилга, авто зам, төмөр зам зэрэг дэд бүтцийн томоохон төслүүд бүс нутагт өрнөж буйтай холбогдуулан энэ чиглэлээр мэргэжилтэн, боловсон хүчинг бодлогоор сургах.
- 1.3.33 Ахмад, залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан чөлөөт цагийг сурч боловсрох танин мэдэх, боломжоор бүрэн хангасан хүний хөгжлийн төвтэй болгох.



#### **1.4. Нийгмийн баталгаа**


- 1.4.1 Ажилгүйдлийг бууруулах зорилгоор шинээр 4000 ажлын байрыг бий болгож хөдөлмөр эрхлэлт, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг 2 дахин бууруулна.

- 1.4.2 Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан бага, дунд орлоготой иргэдийг дэмжих бага хүүтэй зээл олгоход дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 1.4.3 Өрхийн бичил бизнесийг дэмжих Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.4 Оюутан, залууст бизнес эрхлэх, бизнесээ өргөжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц сургалтыг үе шаттай зохион байгуулж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.5 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.4.6 Өрх толгойлсон эцэг эх, 40-өөс дээш насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.7 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн төслүүдээс орон нутгийн иргэд хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хөгжлийн төв”-ийг байгуулж, асрах хүнгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд амьдралын нөхцөлийг нь өөрчлөхгүйгээр өдөр тутмын асрамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.4.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настангууд төрийн болон үйлчилгээний газруудад саадгүй нэвтрэх орц гарцын стандартыг нэвтрүүлж ээлтэй орчин бий болгоно.
- 1.4.10 Залуу үеийнхний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Хөгжлийн хөтөч-Оюунлаг залуучууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.11 Хөдөлмөр зусланг сэргээн ажиллуулж залуу үе, хүүхэд багачуудыг уламжлалт монгол зан заншил, ёс суртахуунд сургах санал санаачлагыг дэмжин ажиллана.
- 1.4.12 Иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэнэ.
- 1.4.13 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, сургууль цэцэрлэгийн орчин, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрэлтдэг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.
- 1.4.14 Хүүхдийн тоглоомын талбай түүний орчин тойронд стандарт тогтоож ойжуулах, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх, хяналтыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хийнэ

- 1.4.15 Залуучууд, залуу гэр бүлийг өрхийн орлогодоо нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууц худалдан авахад нь бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.16 Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлэх, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, хамтран хөгжих мэдлэг боловсролоо дээшлүүлэх, сургалт судалгаа хийх боломжоор хангах зорилгоор “Залуучууд хөгжлийн ордон” барьж ашиглалтанд оруулна.
- 1.4.17 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.4.18 Харъяалалгүй ахмад настан, 70-аас дээш настай ахмадуудад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.19 Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Ахмадын сувилалыг өргөжүүлэх замаар ахмадуудыг амралт, сувилалд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулна.
- 1.4.20 Уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- 1.4.21 Аймаг орон нутгийнхаа нэрийг гаргаж улс бүс, тив дэлхийд өрсөлдөж амжилт гаргаж буй тамирчдаа урамшуулан дэмжих тогтолцоогоо үргэлжлүүлнэ.
- 1.4.22 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн биеийн тамирт хамруулах, спортын багийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ба шаардагдах төсвийг шийдэж ажиллана.
- 1.4.23 Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн бүхий “Хүүхэд залуучуудын парк” шинээр барьж ашиглалтанд оруулна.
- 1.4.24 Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн дарамт, хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, гэр бүл, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.
- 1.4.25 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг хамгаалах Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын түр хамгаалах байрыг тохижуулан төв болгоно.
- 1.4.26 Аймаг, сумдын төвийн гудамж талбайг камерьжуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 1.4.27 Орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.


## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**ЗОРИЛТ:** Эдийн засгийн суурь хөгжлийг ХАА түүний дотроос мал аж ахуй дээр суурилан хөгжих бодлогыг баримтлан нэг хүнд ноогдох ДНБ-ийн хэмжээг уул уурхайн үйлдвэрлэл орохгүйгээр улсын дунджид хүргэх зорилт тавина.



- 2.1. Одоо ашиглагдаж байгаа орд газруудын эдийн засгийн эргэлтийг сайжруулж орон нутгийн төсөвт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 2.2. Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлж дэмжин ажиллана.
- 2.3. Үйлдвэр технологийн паркийг үйл ажиллагааг тогтмолжуулах замаар шинээр ажлын байр нэмэгдүүлнэ.
- 2.4. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хувийн хэвшлийг хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.5. Баруун-Урт сумын хогийн цэгийг дахин шинэчилж орон нутгийн болон олон улсын төсөл хөтөлбөрөөр шинэ технологи нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 2.6. Баруун-Урт суманд Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.7. Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын төвүүдийг байгуулж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэн аялал жуулчлалаас орох орлого, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.8. Баруун-Урт суманд нарны цахилгаан станц ашиглалтанд оруулна.
- 2.9. Аймгийн төвд шахмал түлшний үйлдвэр байгуулж агаарын бохирдлыг бууруулна.
- 2.10. Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ..
- 2.11. Орон нутгийн иргэдийн төлөөллийн байгууллагаас тогтоож хэрэгжүүлдэг татварын шатлалыг үе шаттай бууруулах бодлого баримтална.
- 2.12. Уул уурхайн орлогыг нээлттэй болгох, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, цөлжилт бохирдол зэрэгт төр олон нийтийн анхаарлыг хандуулж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.
- 2.13. Экспортын баримжаатай, орон нутгийн хэрэгцээг бүрэн хангахуйц жижиг дунд үйлдвэрүүдийг сум бүрийн онцлогт нь тулгуурлан байгуулна.

- 2.14. Төсвийн тэнцлийг сайжруулж, төсвийн алдагдалгүй хуримтлалтай аймаг болно.
- 2.15. Татвар хураалтыг цахимжуулж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.
- 2.16. Баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжсэн бодлого зорилтыг төрийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 2.17. Бичигт боомтыг түшиглэн тээвэр, логикийн төв байгуулан хилийн дэд бүтцийг сайжруулж гадаад худалдааг өргөжүүлнэ.
- 2.18. Хашаанд амьдардаг айл өрхүүд хашаандаа ногоон ургамал, мод бут тарих хөдөлгөөнийг өрнүүлж ногоон сум, суурин болох хөдөлгөөнийг өрнүүлнэ..



### **Гурав.ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**ЗОРИЛТ:** *Хөдөө аж ахуй бол аймгийн хөгжлийн гол тулгуур салбар байна.*

- 3.1. Малын гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг хагас боловсруулах жижиг цех, малын тэжээлийн үйлдвэр байгуулах, иргэдийн төсөл хөтөлбөр, санал санаачлагыг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.2. Малын түүхий эдийг боловсруулах цогцолборыг аймгийн төв, зарим сумдад байгуулна.
- 3.3. Малын эмч, зоо-техникч, мал аж ахуйн мэргэжилтнийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, сумдад ажиллах нөхцөл боломжоор хангана.
- 3.4. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээнд сонгомол үйлчилгээтэй стандартын шаардлага хангасан ариутгалын бодис хэрэглэн халдварт өвчний гаралтыг тогтвортой бууруулж, малын гоц халдварт болон халдварт өвчингүй аймаг болно.
- 3.5. Малын эмийн зохистой хэрэглээний журмыг мөрдүүлж, хүн амыг мал, амьтны гаралтай аюулгүй, эрүүл хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.6. МАА-н мэргэжилтэн, малчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, туршлага судлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж шинжлэх ухааны ололт, иновацийг нутагшуулна.
- 3.7. Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулж гоц халдварт өвчингүй, эрүүл тайван бүсийг аймагтаа байгуулж экспортод малын гаралтай бүтээгдэхүүнээ гаргах ажлыг зохион байгуулна.
- 3.8. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн фермерүүдийг бодлогоор дэмжиж сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх бодлого хэрэгжүүлнэ.

- 3.9. Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж орон нутагтаа тарьж ургуулсан төмс, байцаа, манжин, лууван, сонгино зэрэг өргөн хэрэглээний хүнсний ногоо болон нарийн ногоогоор иргэдийн хэрэгцээг орон нутгаасаа хангах бодлогын баримтална.
- 3.10. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны орон нутгийн хэрэгцээг тогтвортой хангана.
- 3.11. Аймагт 1000 м.кв-аас дээш өвлийн хүлэмжтэй болно.
- 3.12. Сүү цагаан идээ, мах, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, урт хугацаанд хадгалах инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлж жилд 100 тн цагаан идээ зах зээлд нийлүүлж, эрүүл мах, махан бүтээгдэхүүнээр хангана.
- 3.13. Малчин өрх бүр, үйлдвэрлэгч байх бодлогыг баримталж, бүтээгдэхүүнийг нь зах зээлд гаргахад нь хаяг боодол, маркетингийн дэмжлэг үзүүлнэ.
- 3.14. “Түмэн цагаан хонь-Түмэн улаан ямаа” төслийн хүрээнд малын үүлдэр угсааг сайжруулах, малчдыг малжуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.15. Жил бүр 200-аас доошгүй малчдыг гадаадын ижил төстэй мал аж ахуйн сургалт, туршлага судлуулах, орчин үеийн мэдээ, мэдээлэл, мэдлэгээр хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.16. Мал амьтдыг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн ажил үйлчилгээний төлбөрийн системийг боловсронгуй болгож, орчин үеийн дэвшилтэт технологи, GPS системийг ашиглан хувийн мал эмнэлгүүдийн ажлын чанарт үнэлгээ тогтоон, тэдгээрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 3.17. Нутгийн үүлдэр омог, хэвшлийн шилмэл малын ашиг шимийн түвшинг хангасан цөм сүргийн сүрэгт эзлэх хувийг 50-аас доошгүй хувьд хүргэнэ.
- 3.18. Эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа, сүү, махны аж ахуйн фермер, малын эрдэст тэжээл, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэж байгаа иргэд, бизнес эрхлэгчдэд хөнгөлттэй нөхцөлөөр бага хүүтэй зээл олгож дэмжлэг үзүүлнэ.
- 3.19. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд Шинэ хоршоо хөдөлгөөнийг эрчимжүүлж, ХАА-н бүтээгдэхүүний түүхий эдийн үнэ ханшийг нэмэгдүүлэх, ашиглах боломжийг бий болгож, орчин үеийн стандартын шаардлага хангасан иж бүрэн үйлдвэр барьж, бүтээгдэхүүнээ экспортлоно
- 3.20. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд Шинэ хоршоо хөдөлгөөнийг эрчимжүүлж Малчдын хоршоог дэмжих замаар махны болон ноос ноолуурын

- боловсруулах үйлдвэрийг хоршоо, иргэдийн хөрөнгө оруулалтаар байгуулж, өөрсдөө хувь, ашгаа хүртдэг байх бодлогыг баримтална.
- 3.21. Хадлангийн бэлчээр нутгийг хамгаалалтанд авах, хашиж хамгаалах үйл ажиллагааг бодлогоор зохицуулж, хадлан эрхлэх малчид, хоршоог дэмжин хадлангийн талбай олголт, ашиглалтыг шилэн болгоно.
- 3.22. Малчдын хоршоо бүлгүүдийг дэмжих замаар шилдэг үүлдэрийн үнээний фермерийн цогцолбор аж ахуй байгуулж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цехийг ашиглалтанд оруулна.
- 3.23. Малчдын хоршоо, нөхөрлөлд хууль эрх зүйн дагуу бэлчээрийн газрыг эзэмшүүлж, хадлангийн болон ногоон тэжээл тарих, ашиглуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж бэлчээр ашиглалтыг сайжруулна.
- 3.24. Худаг усны хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, хөнгөлттэй зээл, тусламжаар малчдын хоршоог гүн өрмийн болон гар худгаар бүрэн хангана.
- 3.25. Малгүй өрхийг малжуулах, дэмжих богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.26. Ширгэсэн болон ширгэж байгаа булаг шандын эхийг хашиж хамгаалах, сэргээх, усан хангамжийг сайжруулах ажлыг тогтмол хийнэ.
- 3.27. Малчдын бүлэг хоршоодыг өвс тэжээлийн агуулахтай болгох ажлыг төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. ДЭД БҮТЭЦ ХОТ БАЙГУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**ЗОРИЛТ:** *Дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлсэн дэд бүтэц, барилга байгууламж, эко орчин бүрдсэн суурин газруудыг бий болгоно.*

- 4.1. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 278 км олон улсын чанартай хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулахад орон нутгаас бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.2. Бичигт боомтын шинэ суурьшлын бүс байгуулсантай холбоотой газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтэц барилга байгууламж барих ажлыг эрчимжүүлнэ.

- 4.3. Баруун-Урт-Сүхбаатар сум-Чойбалсантай холбох хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулахад орон нутгаас бүхий л тадын бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.4. Мэдээлэл холбооны дэд бүтэц, сүлжээний хурд багтаамжийг нэмэгдүүлнэ.
- 4.5. Орон нутгийн төсөвт байгууллагын сүлжээ, интернетийн тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах ажлыг хийж, цахим системд нэвтрүүлж цаасны хэрэглээг багасгана.
- 4.6. Орон нутагт олгогддог тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болно.
- 4.7. Бүх нийтийн цахим ур чадварыг олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж төлөвшсөн "ЦАХИМ ИРГЭН" хөдөлгөөн өрнүүлнэ.
- 4.8. Төрийн үйл ажиллагааны их өгөгдлийг бий болгож, удирдлагын шийдвэр гаргалт хурдан шуурхай, оновчтой байлгах үүднээс удирдлагын нэгдсэн дашбоард бий болгоно.
- 4.9. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн хүний нөөцийг бүрдүүлэх үүднээс төрөөс авч хэрэгжүүлж буй технологийн ажилтан бэлтгэх сургалтанд залуусыг үе шаттайгаар бүрэн хамруулна.
- 4.10. Хиймэл оюун ухаанд суурилсан Сүхбаатар аймгийн үзэсгэлэнт газруудыг багтаасан VR музейг бий болгоно.
- 4.11. Шинэ хоршоо хөдөлгөөнөөр дамжуулж, малчдад старлинкийн интернетийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.12. Сумдын төвийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбож хот төлөвлөлтийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлнэ.
- 4.13. Сумдын төвийг аймгийн төвтэй хатуу хучилттай засмал замаар холбох ажлыг эрчимжүүлж 4 жилд 3-аас доошгүй сумыг холбоно.
- 4.14. Дарьганга 60-н овоо чиглэлийн авто замын төслийг эхлүүлэх.
- 4.15. Нийт сумдын 80 хувиас илүүг нь сум доторх хатуу хучилттай замтай болгоно.
- 4.16. Баруун-Урт-Дарьганга-Шилийн богд чиглэлийн аялал жуулчлалын маршрутын сайжруулсан шороон замын сүлжээг бий болгож, Дарьганга сумыг хатуу хучилттай замаар холбох ажлыг эхлүүлнэ.
- 4.17. Сумдын төвийг ундны ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр иж бүрэн хангана.
- 4.18. Баруун-Уртын ундны эх үүсвэрийг сайжруулж, хотын цэвэр усны шугам сүлжээг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

- 4.19. Баруун-Урт сумын дулаан хангамжийг сайжруулах, нэмэгдүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 4.20. Баруун-Урт хотын дулааны станцыг шинээр өргөтгөх ажлыг хийж дуусгана.
- 4.21. Шинээр баригдах орон сууцны хороолол, шинэ суурьшлийн бүс рүү цэвэр бохирын шугам татах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэнэ.
- 4.22. Цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор сумдын цахилгааны шугам, дэд өртөө шинээр байгуулах ажлыг эрчимжүүлнэ. Мөн шинэ суурьшлийн бүсийн цахилгаан эрчим хүч татах ажлыг эхлүүлнэ.
- 4.23. Баруун-Урт хотод дугуйн замыг ашиглалтанд оруулж “Дугуйтай хот” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.24. Хөдөөгийн иргэдэд холбооны үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор хийгдэж буй хээрийн сайт /холбооны нэмэлт антенууд/-ыг сүлжээгүй газруудад байгуулах ажлыг үргэлжүүлэн хийж нийт нутаг дэвсгэрийг сүлжээтэй болгоно.
- 4.25. Баруун-Урт хотод нийтийн тээврийн үйлчилгээг бий болгож ажиллуулна.
- 4.26. Баруун-Урт сумын гэр хорооллын болон зам гудамжуудыг гэрэлтүүлгээр бүрэн хангах ажлыг үргэжлүүлнэ.
- 4.27. Жишиг баг хөтөлбөрийг сум бүрт хэрэгжүүлнэ.
- 4.28. Асгат, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түвшинширээ сумдад Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барина.
- 4.29. Гэр хорооллын өрхүүдийн дунд бохирын нэгдсэн инженерийн байгууламж байгуулах, био жорлон нэвтрүүлэх замаар хөрсний бохирдлыг багасгана.
- 4.30. Гэр хорооллын айл өрхийг үнс түр хадгалах зориулалтын савтай болгож, үнсийг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.
- 4.31. Баруун-Урт, Эрдэнэцагаан, Баяндэлгэр сумдын гэр хорооллыг дэд бүтцийн шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороололд шилжүүлж, орон сууцаар хангана.
- 4.32. Сумдын халуун усны газрыг шинэчилж, нийтийн ахуйн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулна.
- 4.33. Сүхбаатар аймагт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх Хүнд үйлдвэрлэл технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 4.34. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, цогцолборыг тээвэр кластераар логистикийн хөгжүүлэх тохиромжтой найман байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

- 4.35. Баруун-Урт Нисэх буудлын хөөрч буух зурвасыг бетон хатуу хучилттай 4с ангилалтай олон улсынх болгоно.

**Тав. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Зорилт:** “Аяллын алтан гурвалжин” түүхэн аялал, жуулчлалын бүс нутаг болгоно.


- 5.1. Ганга нуурын болон ширгэж буй нуур цөөрмийн эко системийг хамгаалах, сайжруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2. Аймгийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор тухайн бүс нутгийн эко системд тохирсон төсөл, арга хэмжээг боловсруулж шат дараатай авч хэрэгжүүлнэ.
- 5.3. Аймгийн хэмжээний уул уурхайн лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах ажлыг зохион байгуулна.
- 5.4. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг чангатгана.
- 5.5. Үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайд тавих хяналтыг сайжруулж нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 5.6. Бичигт боомтод үйл ажиллагаа явуулж буй тээврийн компаниудтай хамтран орчны бохирдол, тоосжилт, хөрсний эвдрэл доройтлыг бууруулах хашаажуулах, нэгдсэн сайжруулсан зам талбайтай болгох, нөхөн сэргээх ажлыг эхлүүлнэ.
- 5.7. Бичигт боомт дээр шинээр газар олголтыг зогсоож, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хийнэ.
- 5.8. Бичигт боомтын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 5.9. Бичигт боомтын нэгдсэн ачаа тээврийн терминалыг тогтоож, төр хувийн хэвшлийн хамтын хүрээнд орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан байгаль орчинд ээлтэй зам талбай бүхий байгууламжийг ашиглалтанд оруулна.

- 5.10. Уул уурхайн тээвэрлэлтийг батлагдсан маршрутын дагуу стандартын жин тонныг мөрдөж шаардлагатай газруудад тусгай зориулалтын авто замыг бариулах ажлыг зохион байгуулна.
- 5.11. Баруун-Уртын голын үерийн даланг сайжруулан тохижуулж амралт, зугаацлын орчин бүрдүүлнэ.
- 5.12. Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг дуусгана.
- 5.13. Аймаг сумдын төвүүдийг ногоон бүс-эко орчин болгох төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.14. Сумдад цэцэрлэгжилт, хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан тохижилтын нэгжийг байгуулан ажиллуулна.
- 5.15. Бэлчээрийн менежментийг сайжруулан талхлагдсан газар нутгийг өнжөөх, сэлгэх, ойжуулах замаар хөрс хамгаалах бодлогыг эрчимтэй явуулна.
- 5.16. Ховордсон ан амьтан /тарвага, аргаль, чоно гэх мэт/, нэн ховор, ховор ургамал, амьтны төрөл зүйлийг нэмэгдүүлэх, нутагшуулах, тоо толгойг нэмэгдүүлнэ.
- 5.17. Тал хээрийн түймрээс иргэдийн амь нас, эд хөрөнгө, мал сүргийг хамгаалах төлөвлөгөөг гаргаж урьдчилан сэргийлэх, алслагдсан нутгийн малчдыг шаардлагатай багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авна.
- 5.18. Бэлчээр нутгийг усжуулах бодлогыг хэрэгжүүлж жил бүр 10-аас доошгүй худгийг гаргаж малчдад гэрээгээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.19. Баруун-Урт болон сумдад иргэдийн амарч тухлах, чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- 5.20. Эзэмшил газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, шинээр бий болгосон иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, гэр хорооллын айл өрхийн ногоон стандартыг бий болгож мөрдүүлнэ.
- 5.21. Баруун-Урт болон нийт сумдын гудамж, талбай, байшин барилгын нэр, хаягийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж нэгдсэн стандартад нийцүүлнэ.
- 5.22. Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр, түүх, соёл, байгаль, хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд бүсийн төв байгуулан төр хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллана.
- 5.23. Алтан овоо, Шилийн богд, Талын агуй зэрэг түүхэн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын дэд бүтцийг шинээр байгуулна.

Амгалант  
Түвшин  
Дорнод  
Уул

2217144021  
ЛН0А0042 9054561

- 5.24. Дарьганга суманд тахилгат хайрхад, хүн чулуун хөрөгт түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор байгуулна.
- 5.25. Аялал, жуулчлалын чиглэлээр мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэн байгуулна.
- 5.26. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ
- 5.27. “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх мод тарих ажлыг эрчимжүүлж, иргэн, байгууллага бүр мод тарих хөдөлгөөнийг дэмжин хамтран ажиллана.
- 5.28. Баруун-Урт болон сумдын гэр хорооллын модон жорлонг орчин үеийн эко, байгальд ээлтэй шийдлээр шидэх ажлыг өрнүүлнэ



**Зургаа:Хил хамгаалах салбарын бодлого**

**Зорилт:** *Хил амгалан бол иргэд амгалан*

- 6.1. Наран, Дарьганга, Баяндэлгэр, Онгон, Эрдэнэцагаан сумдын хилийн торыг шинэчлэх, бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлж, улсын хилийн хамгаалалтыг сайжруулна.
- 6.2. Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад анхаарч, бодлогоор дэмжлэг үзүүлж ажиллана.
- 6.3. Хил хамгаалах салбарыг сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмж хэрэгслээр хангах материаллаг баазыг сайжруулах ажлын хүрээнд шат дараатай хамтран ажиллана.
- 6.4. Хил хамгаалах байгууллагын ажилтнуудын гэр бүлийг ажлын байраар хангах хүүхдүүдийг сурч боловсрох цэцэрлэг сургуульд хамруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- 6.5. Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг сургаж дадлагажуулах, идэвхжүүлэх, нийгмийн баталгааг хангах, гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан чадавхжуулах талаар хилийн сумдын удирдлагууд, Хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллана.

**Долоо.ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

**ЗОРИЛТ:** *Нээлттэй бодлого хэрэгжүүлж, шилэн тайлангналыг бий болгож иргэдийн төрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.*

- 7.1. Төрийн байгууллагуудад цахим үйлчилгээг нэвтрүүлж хүнд суртал, авилгыг таслан зогсооно.
- 7.2. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.
- 7.3. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 7.4. Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.
- 7.5. Төрийн албанд шатлан дэвших /мерит/ зарчмыг чанд мөрдүүлнэ.
- 7.6. Бүх шатны шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангаж төр, иргэний түншлэл хамтын ажиллагааг шинэ шатанд гаргана.
- 7.7. Аймаг, орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хариуцлагыг дээшлүүлж, хууль дээдлэх зарчмыг мөрдлөг болгон ажиллана.
- 7.8. Төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг Иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар зардлыг бууруулж, ачааллыг багасган ажиллана.
- 7.9. Гадаад бодлогын хүрээнд хөрш зэргэлдээ улс орнуудтай нийгэм, эдийн засгийн бүхий л чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 7.10. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, бага хүүтэй зээлд хамруулах, гадаад дотоодод урт богино хугацааны сургалтад хамруулах, үйл ажиллагааны үр дүнгээр шагнаж урамшуулах зэргээр нийгмийн баталгааг ханган ажиллана.
- 7.11. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ

СҮХБААТАР АЙМГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

2024 оны 06 сарын 24-ны өдөр